



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/431

Арвайхээр

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 70 дугаар дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилтээр санхүүжих Мал угаалгын ванн шинээр барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 54780000 (тавин дөрвөн сая долоон зуун наян мянга) төгрөгөөр “Баяжих ундарга” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100724